

Хамтран ажиллах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн үүргийн тухай нийтлэг үндэслэл, 476-480 дугаар зүйл, Банкны тухай хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг тус тус үндэслэн,

нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо 14210 Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх),

нөгөө талаас

хаягт

орших

(цаашид “Мерчант” гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гэрээгээр Банк нь Visa Inc, MasterCard Worldwide, JCB International, UnionPay International, Diners Club International, Discover Financial Service байгууллагын гишүүн банк болон банк бус санхүүгийн байгууллагууд, дотоодын банкуудаас гаргасан бүх төрлийн төлбөрийн карт (цаашид “Карт” гэх)-уудыг төлбөрт хүлээн авах эрх бүхий онлайн үйлчилгээ, ПОС терминал, IPPOS терминал, Happy Pay мерчант терминал, И-коммерс терминал, Apple Pay и-коммерс терминал, Дундын ПОС терминал, Qpay QR терминал, TDB QR терминал, Цахим хэтэвчний In-app, Deeplink үйлчилгээ болон Ви чат пэй үйлчилгээг ашиглан гүйцэтгэсэн төлбөр тооцоог банкна дахь дансаар дамжуулан, мерчантад олгож, түүгээр гүйцэтгэсэн төлбөр тооцоог мерчантад шилжүүлэх, мерчант нь уг эрхийнхээ хүрээнд төлбөрийн картаар карт эзэмшигч, Хэрэглэгч нарт үйлчилгээ үзүүлэх болон эдгээртэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулна.

1.2. Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “Мерчант” гэж бараа, үйлчилгээнийхээ төлбөрийг картаар, интернэтээр, ПОС терминал, IPPOS терминал, Happy Pay мерчант терминал, И-коммерс терминал, Apple Pay и-коммерс терминал, Дундын ПОС терминал, Qpay QR терминал, TDB QR терминал, Цахим хэтэвчний In-app, Deeplink үйлчилгээ болон Ви чат пэй үйлчилгээг ашиглан төлбөрт хүлээн авах хамтран ажиллах гэрээг Банктай байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

1.2.2. “Терминал” гэж бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг хүлээн авах зориулалттай тоног төхөөрөмж, программ хангамж, ухаалаг төхөөрөмжид суурилсан аппликейшны шийдэл бүхий цахим мэдээ үүсгэгчийг;

1.2.3. “ПОС терминал” гэж төлбөрийн карт, QR код, бусад төлбөрийн хэрэгслийн гүйлгээний мэдээллийг цахим хэлбэрээр шалгах, зөвшөөрлийн код авах, гүйлгээг буцаах, гүйлгээг лавлах, гүйлгээний баримтыг хэвлэх зэрэг үндсэн зориулалт бүхий банкны процессингийн сүлжээнд холбогдсон, мерчантад суурилуулсан төхөөрөмжийг;

1.2.4. “IPPOS терминал” гэж TCP/IP протоколыг ашиглан мерчантын кассын төхөөрөмжөөс гүйлгээний мэдээллийг Банк руу нууцлалтайгаар дамжуулж хариуг хүлээн авах зориулалт бүхий программ хангамж бүхий төхөөрөмжийг;

1.2.5. “Дундын ПОС терминал” гэж 3 хүртэлх мерчант холбож картын гүйлгээ хүлээн авах боломж бүхий банкны процессингийн сүлжээнд холбогдсон төхөөрөмжийг;

1.2.6. “WeChat Pay терминал” гэж IOS, android үйлдлийн системтэй гар утас, таблет, кассын систем, android үйлдлийн системтэй ПОС терминалд суурилсан TDB POS аппликейшнийг ашиглан ви чат пей хэрэглэгчдийн гүйлгээг хүлээн авах төлбөр тооцооны сувгийг;

1.2.7. “И-коммерс терминал” гэж интернет худалдааны зорилгоор тусгайлан боловсруулсан мерчантын цахим хуудсыг банкны системд холбон бэлэн бус төлбөрийн хэрэгслийг төлбөрт хүлээн авах боломж бүхий цахим программ хангамжийг;

1.2.8. “Apple Pay и-коммерс терминал” гэж интернэт худалдааны зорилгоор тусгайлан боловсруулсан мерчантын цахим хуудсыг банкны системд холбон Apple pay хэвэтчээр төлбөрт хүлээн авах боломж бүхий цахим программ хангамжийг;

1.2.9. “Happy Pay мерчант терминал” гэж төлбөрийн картын мэдээллийг зайнаас уншуулж гүйлгээнд цахим хэлбэрээр зөвшөөрөл авах, гүйлгээг буцаах, гүйлгээг лавлах агуулга бүхий банкны процессингийн сүлжээнд холбогдсон, ухаалаг төхөөрөмжид суурилах цахим мэдээ үүсгэгчийг;

1.2.10. “Qpay QR терминал” гэж Процессор байгууллагаас гаргасан QR код ашиглан гүйлгээний мэдээллийг цахим хэлбэрээр шалгах, зөвшөөрлийн код авах, гүйлгээг буцаах, гүйлгээг лавлах агуулга бүхий банкны процессингийн сүлжээнд холбогдсон, ПОС терминал болон ухаалаг төхөөрөмжид суурилах цахим мэдээ үүсгэгчийг;

1.2.11. “TDB QR терминал” гэж Банкнаас гаргасан QR код ашиглан гүйлгээний мэдээллийг цахим хэлбэрээр шалгах, зөвшөөрлийн код авах, гүйлгээг буцаах, гүйлгээг лавлах агуулга бүхий банкны процессингийн сүлжээнд холбогдсон, ПОС терминал болон ухаалаг төхөөрөмжид суурилах цахим мэдээ үүсгэгчийг;

1.2.12. “Карт” гэж Visa Inc, MasterCard Worldwide, JCB International, UnionPay International, Diners Club International, Discover Financial Service зэрэг олон улсын санхүүгийн байгууллагын гишүүн бүхий аливаа банк, банк бус санхүүгийн байгууллагууд, дотоодын банкуудаас гаргасан бүх төрлийн төлбөрийн картыг;

1.2.13. “Карт эзэмшигч” (цаашид “Хэрэглэгч” гэх) гэж карт гаргагч банкаас тухайн хүний нэр дээр олгосон картан хууль ёсны хэрэглэгч иргэн, хуулийн этгээдийг;

1.2.14. “QR код хэрэглэгч” (цаашид “Хэрэглэгч” гэх) ухаалаг төхөөрөмжид суурилсан цахим банкны аппликейшн дахь QR код унших тусгай цэсийг ашиглан цахим хэлбэрээр төлбөр тооцоо гүйцэтгэх иргэн, хуулийн этгээдийг;

1.2.15. “Ви чат пэй хэрэглэгч” (цаашид “Хэрэглэгч” гэх) ухаалаг төхөөрөмжид суурилсан Ви чат аппликейшн дээр Хятадын банкны дансаа холбож цахим хэлбэрээр төлбөр тооцоо гүйцэтгэх Ви чат пэй үйлчилгээний хууль ёсны хэрэглэгч иргэн, хуулийн этгээдийг;

1.2.16. “Happy Pay мерчантын үйлчилгээ” гэж картан мэдээллийг зайнаас уншуулж гүйлгээнд цахим хэлбэрээр зөвшөөрөл авах, гүйлгээг буцаах, гүйлгээг лавлах агуулга бүхий ухаалаг төхөөрөмжид суурилах технологийн шийдлийг;

1.2.17. “Happy Pay - Merchant аппликейшн” гэж “Happy Pay мерчантын үйлчилгээ” технологийн шийдлээр хөгжүүлэгдсэн, ухаалаг төхөөрөмжид суурилах тусгай зориулалт бүхий аппликейшнийг;

1.2.18. “Ви чат пэй үйлчилгээ” гэж банкны мерчантын ухаалаг төхөөрөмжид суусан TDB POS аппликейшн ашиглан Ви чат пэй хэрэглэгчийн QR кодыг уншуулж цахим хэлбэрээр олон улсын гүйлгээг төлбөрт хүлээн авах үйлчилгээг;

1.2.19. **“TDB POS аппликейшн”** гэж Ви чат пэй аппликейшнээр хийгдэж буй гүйлгээг хүлээн авах, гүйлгээг буцаах, гүйлгээг лавлах агуулга бүхий банкны ПОС терминал эсхүл мерчантын хариуцсан ажилтны гар утсанд сууриллагдах тусгай зориулалт бүхий аппликейшнийг;

1.2.20. **“QR код”** гэж картын төлбөр хүлээн авах зориулалт бүхий олон улсын EMVCo стандартын дагуу гаргасан хурдан хариу өгөх кодыг;

1.2.21. **“Qpay QR кодоор төлбөрт хүлээн авах үйлчилгээ”** (цаашид “Qpay QR үйлчилгээ” гэх) гэж Процессор байгууллагаас гаргасан QR стикер код болон ПОС терминалын дэлгэцэнд үүссэн QR код ашиглан Банкны ухаалаг банк аппликейшн дахь QR код унших тусгай цэсээр төлбөр төлөх боломжийг Хэрэглэгчид хүргэж буй үйлчилгээг;

1.2.22. **“TDB QR кодоор төлбөрт хүлээн авах үйлчилгээ”** (цаашид “TDB QR үйлчилгээ” гэх) гэж Банкны QR стикер код болон ПОС терминалын дэлгэцэнд үүссэн QR код ашиглан Банкны ухаалаг банк аппликейшн дахь QR код унших тусгай цэсээр төлбөр төлөх боломжийг Хэрэглэгчид хүргэж буй үйлчилгээг;

1.2.23. **“QR мерчант аппликейшн”** гэж бараа, ажил, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын борлуулалтын тайлан харах, QR кодоор үнийн дүн илгээх, төлбөр хүлээн авах, дансны мэдээллийг удирдах зориулалт бүхий ухаалаг гар утасны аппликейшнийг;

1.2.24. **“QR кодоор төлбөрт хүлээн авагч”** (цаашид “Qpay QR мерчант” гэх) гэж борлуулсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрөө QR стикер болон ПОС терминалд үүссэн QR код ашиглан Банк дахь дансанд хүлээн авахаар Банктай “Мерчанттай хамтран ажиллах гэрээ” байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

1.2.25. **“Цахим хэтэвч үйлчилгээ”** (монголоор “Цахим хэтэвч”, англиар “Happy Pay” гэх) гэж “Цахим хэтэвч” мобайл аппликейшнээр дамжуулан, харилцагчид банкны болон хамтран ажиллах гэрээний дагуу бусад бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж буй цахим сувгийг;

1.2.26. **“Цахим хэтэвчний In-app үйлчилгээ”** гэж Цахим хэтэвч аппликейшний үйлчилгээ цэсэнд байрлах бүтээгдэхүүн үйлчилгээг;

1.2.27. **“Цахим хэтэвчний Deeplink үйлчилгээ”** гэж гуравдагч байгууллагын аппликейшны төлбөр төлөх хэсэгт харуулж, төлбөр төлөх үед цахим хэтэвч аппликейшн руу шилжиж төлбөр төлөх үйлчилгээг;

1.2.28. **“Apple pay”** гэж iPhone, Apple Watch, iMac зэрэг Apple-ийн төхөөрөмжүүдэд банкны картаа холбон гүйлгээ хийх боломжтой дижитал хэтэвчийг;

1.2.29. **“Худалдан авалтын гүйлгээ”** (цаашид “Гүйлгээ” гэх) гэж Хэрэглэгч нь Мерчантаас худалдан авч буй бараа, үйлчилгээний үнийг Карт, QR код эсхүл Ви чат пэй үйлчилгээг ашиглан төлж буй гүйлгээг;

1.2.30. **“Гүйлгээний баримт”** гэж картын дугаар, хүчинтэй хугацаа, огноо, гүйлгээний дүн, гүйлгээ хийх валютын нэр, Хэрэглэгчийн гарын үсэг, зөвшөөрлийн код, мэдээллийг агуулсан ПОС терминалаар хэвлэгдэн гарсан төлбөрийн баримтыг, IPPOS терминалын хувьд кассын системээс хэвлэгдэн гарсан төлбөрийн баримтыг, и-мерчант болон Apple Pay и-мерчантын хувьд гүйлгээнд зөвшөөрөл авсны дараа баталгаажуулах шаардлагын дагуу гүйлгээний мэдээллийг холбогдох цахим шуудангийн хаяг руу илгээх төлбөрийн мэдээллийг, Happy Pay мерчант терминалын хувьд Happy Pay - Merchant аппликейшны гүйлгээний жагсаалт цэсэнд хадгалагдах төлбөрийн мэдээллийг, Qpay QR терминалын хувьд QR мерчант аппликейшны төлбөрийн түүх цэсэнд хадгалагдах төлбөрийн мэдээллийг, Ви чат пэй мерчантын хувьд TDB POS аппликейшны лавлагаа цэсэнд хадгалагдах төлбөрийн мэдээллийг;

1.2.31. **“Терминал дугаар”** гэж тухайн ПОС терминал, IPPOS терминал, И-коммерс терминал, Apple Pay и-коммерс терминал, Happy Pay мерчант терминал, Qpay QR терминал, TDB QR терминал, Цахим хэтэвчний In-app, Deeplink үйлчилгээ болон Ви чат пэй үйлчилгээнд холбоотой байгаа мерчантуудын гүйлгээг ялгах зорилгоор банкны системээс өгөгдөж байгаа дугаарлалтыг;

1.2.32. **“Зөвшөөрлийн код”** гэж Банкнаас уг гүйлгээг шалгаж тухайн карт, ПОС терминал, IPPOS терминал, И-коммерс терминал, Apple Pay и-коммерс терминал, Happy Pay мерчант терминал, Qpay QR терминал, TDB QR терминал, Цахим хэтэвчний In-app, Deeplink үйлчилгээ болон Ви чат пэй үйлчилгээгээр гүйлгээний дүнд бараа, үйлчилгээ худалдаж авч болохыг нотолж илгээсэн дугаарыг;

1.2.33. **“Интернэт ПИН код”** гэж карт эзэмшигч нар интернэтээр төлбөр хийхэд ашиглах нууцлалын дугаарыг;

1.2.34. **“Админ ПИН код”** гэж Happy Pay мерчант терминал дээр Цуцлах гүйлгээ хийх үед ашиглах дөрвөн оронтой нууцлалын дугаарыг;

1.2.35. **“Картын нууцлалын дугаар”** гэж картын ар талд байрлах картын мэдээллийн нууцлалыг хадгалсан гурван оронтой нууцлалын CVV кодыг;

1.2.36. **“Гараар гүйлгээ хийх”** буюу Manual entry гэж Банкны зүгээс байгууллагад суурилуулж өгсөн тусгай тохиргоо бүхий ПОС терминал дээр дотоодын болон олон улсын банкны картуудыг төлбөрт хүлээн авах зорилгоор аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд биет бусаар зөвхөн картын мэдээллийг ашиглан төлбөр хүлээн авахыг”

1.2.37. **“Буцаах гүйлгээ”** гэж зөвшөөрлийн кодыг цуцлах хугацаа өнгөрсөн үед гүйлгээний дүнг Мерчантын дансанд шилжүүлсний дараа төлбөрийг буцаан Хэрэглэгчийн данс руу шилжүүлэхийг;

1.2.38. **“Цуцлах гүйлгээ”** гэж зөвшөөрлийн кодыг цуцлах хугацааны дотор буюу гүйлгээний дүнг Мерчантын дансанд шилжүүлэхээс өмнө төлбөрийг буцаан Хэрэглэгчийн данс руу шилжүүлэхийг;

1.2.39. **“Зөвшөөрөгдөөгүй гүйлгээ”** гэж Банкны системд хийхийг зөвшөөрөөгүй гүйлгээг;

1.2.40. **“Маргаантай гүйлгээ”** гэж карт эзэмшигч, QR код, Ви чат пэй хэрэглэгч эсвэл Мерчантын зүгээс гүйлгээг хүлээн зөвшөөрөхгүй, эсхүл үлдэгдлээ үнэн зөв эсэхэд эргэлзэж гүйлгээний хүчинтэй эсэх талаар бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу маргаан үүсгэж хянагдаж буй гүйлгээг;

1.2.41. **“Хасалтын гүйлгээ”** гэж Хэрэглэгчийн зүгээс өөрийн данс байршиж буй, карт гаргасан банканд маргаантай гүйлгээ үүсгэж, Монголбанк, Visa Inc, MasterCard Worldwide, JCB International, UnionPay International, Diners Club International, Discover Financial Service-ийн маргаан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлүүлэн, Мерчантаас суутгаж авах үед хийгдэх гүйлгээ, Ви чат пэй хэрэглэгчийн зүгээс өөрийн банканд маргаантай гүйлгээ үүсгэн маргаан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлүүлэн Мерчантаас суутгаж авах үед хийгдэх гүйлгээг;

1.2.42. **“Луйврын шинжтэй гүйлгээ”** гэж алдагдсан, гээгдсэн, Visa, MasterCard, JCB, CUP, Diners Club, Discover болон “T” картын стандартыг хангаагүй хуурамч картаар болон Хэрэглэгчээс өөр хувь хүн төлбөр гүйцэтгэх гүйлгээг;

1.2.43. **“Маргаантай гүйлгээ шалгуулах хүсэлт”** гэж Банкнаас маргаантай гүйлгээг шалгуулах гүйлгээний баримтыг нэхэмжлэхээр Мерчантанд хугацаа зааж илгээсэн баримтыг;

1.2.44. **“Мерчантын данс”** (цаашид “Данс” гэх) гэж тухайн Мерчантаас картын төлбөр тооцоо болон Qpay QR үйлчилгээ, TDB QR үйлчилгээ, Ви чат пэй үйлчилгээний төлбөр тооцоог хүлээн авах зорилгоор Банканд өгсөн Монгол Улсын арилжааны банкууд дахь ам.долларын хадгаламжийн данснаас бусад бүх төрлийн дансыг;

1.2.45. **“Түр данс”** гэж Банкны картын бүртгэлийн үндсэн системээр тухайн терминал дээр гарч буй гүйлгээг бүртгэх зориулалт бүхий түр дансыг хэлнэ;

1.2.46. **“Процессор байгууллага”** гэж Банк нь Qpay QR, WeChat Pay, In-app, Deeplink болон Happy pay мерчантын үйлчилгээ үзүүлэхээр хамтран ажиллах гэрээ байгуулсан байгууллагыг;

1.2.47. **“Худалдаа, хөгжлийн банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”** (цаашид “Ерөнхий нөхцөл” гэх) гэж олон нийтэд зарласан Банкны Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдан мөрдөгдөж буй Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний хүү, шимтгэлийн нөхцөлүүдийг агуулсан баримт бичгийг;

1.3. Гэрээний дагуу Банкнаас Мерчантанд суурилуулах ПОС терминал, түүний дагалдах сэлбэг, хэрэгсэл нь Банкны өмч байна.

ХОЁР. МЕРЧАНТАД ТАВИХ ШААРДЛАГА

2.1. Мерчант нь төлбөрийг картаар, QR код, Ви чат пэй болон и-мерчант болон Apple Pay и-мерчант үйлчилгээгээр хүлээн авахтай холбоотойгоор дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана:

2.1.1. ПОС терминалын тэжээлийн эх үүсвэрийг найдвартай байлгаж, аливаа цахилгааны богино холболт үүсгэх нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх;

2.1.2. ПОС терминалыг цэвэр орчинд байлган, ариг гамтай хэрэглэж, элдэв эвдрэл, гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх;

2.1.3. Нэг сард нэгж ПОС терминалаар хийгдэх гүйлгээний нийт дүн нь гурван сая төгрөгөөс багагүй байх;

2.1.4. Мерчант нь төлбөр хүлээн авахад ашиглах ухаалаг утас, дата үйлчилгээгээр өөрийн ажилтнуудаа хангасан байх;

2.1.5. Нарру Pay мерчант нь андройд төрлийн үйлдлийн систем бүхий ухаалаг төхөөрөмж дээрээ Happy Pay - Merchant аппликейшныг татан суулгасан байх;

2.1.6. Ви чат пэй мерчант нь IOS болон андройд төрлийн үйлдлийн систем бүхий ухаалаг төхөөрөмж дээрээ TDB POS аппликейшныг татан суулгасан байх эсхүл банкнаас олгосон ПОС терминалтай байх;

2.1.7. И-мерчант болон Apple Pay и-мерчант нь SSL нууцлалын сертификат бүхий цахим хуудастай байх;

2.1.8. И-мерчант болон Apple Pay и-мерчант нь интернэтэд байрлуулсан өөрийн хаяг бүхий цахим хуудсаараа дамжуулан бараа, бүтээгдэхүүнийг худалдан авагчдад онлайн хэлбэрээр худалдах, төлбөрийг картаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.1.9. И-мерчант болон Apple Pay и-мерчант нь вэбсайтад байгууллагын албан ёсны нэр, утасны дугаар, цахим шуудангийн хаягийн мэдээллийг тодорхой, ойлгомжтой байршуулсан байх;

2.1.10. И-мерчант болон Apple Pay и-мерчант нь Банканд данстай байх ба орлого хүлээн авах данс нь зөвхөн төгрөгийн харилцах данс байх;

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ, ХУРААМЖ

3.1. Банк нь Мерчантын гүйлгээ бүрээс Ерөнхий нөхцөлд заасны дагуу гүйлгээний шимтгэл (цаашид “Шимтгэл” гэх) авна. Мерчант нь ерөнхий нөхцөлийн шимтгэлтэй танилцаж, зөвшөөрсөн бөгөөд энэ нь Гэрээг байгуулах урьдчилсан нөхцөл болохыг талууд харилцан тохиролцов.

3.2. И-мерчант нь өөрийн цахим хуудсандаа төлбөрийн картаар гүйлгээ хийх эрхтэйгээр холболт хийлгэсний төлөө холболтын хураамж төлнө.

3.3. Ерөнхий нөхцөлд заасан холбогдох шимтгэлийн хэмжээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг Банк тухай бүр өөрийн www.tdbm.mn цахим хуудсаар дамжуулан нийтэд зарласнаар Мерчантад мэдээлсэнд тооцогдож хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

ДӨРӨВ. ТӨЛБӨР ШИЛЖҮҮЛЭХ

4.1. ПОС терминал, IPPOS терминал, И-коммерс терминал, Apple Pay и-коммерс терминал, Нарру Pay мерчант терминал, Qpay QR терминал, TDB QR терминал, Цахим хэтэвчний In-app, Deeplink үйлчилгээ болон Ви чат пэй үйлчилгээгээр гүйцэтгэсэн төлбөрийг Банк шимтгэл суутгасан дүнгээр Мерчантын данс руу гүйлгээ хийгдсэн өдрийн дараагийн хуанлийн өдөрт шилжүүлэх ба и-мерчантаар дотоодын төлбөрийн картаар хийгдсэн гүйлгээний төлбөрийг гүйлгээ хийгдсэнээс хойш хуанлийн 2 (хоёр) өдөрт харин болон олон улсын банкны картаар хийгдсэн и-мерчант болон Apple Pay и-мерчант гүйлгээний төлбөрийг гүйлгээ хийгдсэнээс хойш хуанлийн 1-5 (нэгээс тав) өдрийн дараа шилжүүлнэ.

4.2. Мерчантын зүгээс худалдан авалтын гүйлгээг цуцлах болон буцаах гүйлгээ хийсэн тохиолдолд тухайн үед суутган авсан гүйлгээний шимтгэлийг Банк Мерчантад буцаан олгоно.

4.3. Мерчант дээр залилангийн буюу луйврын шинж чанартай гүйлгээ гарсан гэж Банкны зүгээс үзсэн, эсхүл Маргаантай гүйлгээ гарч Мерчантаас хасалтын гүйлгээ гарсан тохиолдолд төлбөрийг данснаас шууд суутган авах буюу уг маргаантай болон сэжигтэй гүйлгээний төлбөрийг барагдуулж дуустал гүйлгээний дүнг Мерчантад шилжүүлэхгүй байна.

ТАВ. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Банк дараах үүрэгтэй:

5.1.1. Төлбөр хүлээн авах зориулалтаар Мерчантыг ПОС терминал болон бусад төрлийн терминал, карт төлбөрт хүлээн авах сургалт, гарын авлага, таних тэмдгээр үнэ төлбөргүй хангах;

5.1.2. Төлбөр хүлээн авах сувгаар дамжуулан гүйцэтгэсэн төлбөрийг Гэрээнд заасан журмаар саадгүй, түргэн шуурхай шилжүүлэх;

5.1.3. Мерчантын данс болон гүйлгээний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, нууцлалыг хадгалах;

5.1.4. Банк шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд энэхүү өөрчлөлтөө Мерчантад нэн даруй мэдэгдэх;

5.1.5. Картын болон Ви чат пэй төлбөр тооцоотой холбогдон Хэрэглэгч болон Мерчантын хооронд үүссэн аливаа маргаантай асуудлыг Visa Inc, MasterCard Worldwide, JCB International, UnionPay International, Diners Club International, Discover Financial Service, Tencent, Монголбанкны төлбөр тооцооны төвийн маргаан шийдвэрлэх дүрмийн дагуу Хэрэглэгч, Мерчантын аль нэг талын хүсэлтээр 3 талын оролцоотойгоор шийдвэрлэх;

5.1.6. Мерчантын хүсэлтийн дагуу Visa Inc, MasterCard Worldwide, JCB International, UnionPay Inc, Diners Club International, Discover Financial Service, Tencent тэдгээрийн гишүүн байгууллагуудтай түүнийг төлөөлөн харьцаж эрх ашгийг нь хамгаалах;

5.1.7. Луйврын шинж чанартай гүйлгээнд хяналт тавих, хязгаарлах, и-мерчантын холбогдох ажилтнуудтай хамтран шалгах, түр хугацаагаар уг интернэт худалдааг зогсоох, хууль зөрчсөн аливаа үйл ажиллагааг хууль хяналтын байгууллагад мэдэгдэх;

5.1.8. Хууль болон Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх.

5.2. Банк дараах эрхтэй:

5.2.1. Үйлчилгээний шимтгэлийг ерөнхий нөхцөлд заасны дагуу Мерчантаас Гэрээнд заасан журмаар суутган авах;

5.2.2. Хэрэглэгчийн гомдлын дагуу Мерчантаас гүйлгээний баримт, тооцооны хуудас болон бусад гүйлгээ хийсэн талаарх нотлох баримтуудыг нэхэмжлэн шаардах;

5.2.3. Мерчант Гэрээгээр хүлээсэн үүрэг, үйлчилгээний журмыг зөрчсөнөөс үүдэн Хэрэглэгч, Банканд учруулсан аливаа хохирол, зардлыг Мерчантын түр данс болон бусад банканд дахь тоот харилцах данснаасаа суутгаж хохирлыг барагдуулах буюу хохирлыг барагдуулж дуустал гүйлгээний дүнг шилжүүлэхгүй байх;

5.2.4. Мерчантаас Хэрэглэгчдэд аливаа хүндрэл учруулахгүйгээр найдвартай шуурхай үйлчилгээ үзүүлэхийг шаардах;

5.2.5. ПОС терминалын эвдрэл гэмтлийг нөхөн төлөх болон Гэрээний дагуу Мерчантаас Банкны өмнө хүлээсэн мөнгөн төлбөрийг Гэрээний 5.2.3 дахь заалтад заасны дагуу барагдуулах;

- 5.2.6. Маргаантай гүйлгээ гарсан үед “Маргаантай гүйлгээ шалгуулах хүсэлт”-ийг хүргүүлж, банкнаас заасан хугацааны дотор хариу ирүүлэхийг шаардах;
- 5.2.7. Гүйлгээ баталгаажуулах маягтын хариуг болон гүйлгээний баримтыг ирүүлээгүй, эсхүл картыг төлбөрт хүлээн авах стандартыг хангаж ажиллаж чадсанаа баталж чадахгүй бол тухайн гүйлгээг үл маргах журмаар уг гүйлгээний дүн шилжсэн данснаас шууд суутган авах, эсхүл картаар гүйцэтгэсэн дүнгээр битүүмж тавих;
- 5.2.8. Мерчант ПОС терминалыг хулгайд алдсан, үрэгдүүлсэн, эсхүл ус оруулах, унагаах гэх мэтийн засагдашгүй байдлаар гэмтээсэн тохиолдолд тухайн төхөөрөмжийн үнийг банкнаас элэгдэл тооцсон дүнгээр, сэлбэг хэрэгслийг зах зээлийн үнээр нэхэмжилж төлүүлэх;
- 5.2.9. Луйврын шинж чанартай гүйлгээнд хяналт тавих, хязгаарлах, Мерчантын холбогдох ажилтнуудтай хамтран ажиллах, хууль зөрчсөн аливаа үйл ажиллагааг хууль хяналтын байгууллагад мэдэгдэх, луйврын гүйлгээнээс урьдчилан сэргийлж, хуурамч картыг хураан авсан Мерчантын ажилтанд зохих урамшууллыг олгох;
- 5.2.10. Мерчантаас картын тоног төхөөрөмж болох ПОС терминал, интернэт холболтыг зориулалтын дагуу ашиглахыг шаардах, хянах;
- 5.2.11. Мерчант нь Гэрээний 6.1.7 дахь заалтыг удаа дараа зөрчсөн (Гэрээний үүргээ зөрчсөн тухай сануулах шаардлагагүй), эсхүл гурван сарын хугацаанд Гэрээний 2.1.3-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд болон энэ Гэрээнд заасан бусад үндэслэлээр Банк ПОС терминалыг буцаан авах;
- 5.2.12. ПОС терминалын засвар үйлчилгээтэй холбоотойгоор Банкны ажилтан ажлын үнэмлэхээ шалгуулж, хүлээлцэх акт үйлдэн ПОС терминалыг 3 хоног хүртэлх хугацаагаар засварлуулахаар авч явах, сольж өгөх;
- 5.2.13. Банк Гэрээний 6.1.20 дахь заалтад заасан үүргээ биелүүлээгүй, шимтгэлийг төлөөгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөс үл маргах журмаар суутган авах;
- 5.2.14. Мерчант нь Хэрэглэгчдэд картаар, QR код болон Ви чат пэй үйлчилгээгээр үйлчлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан, ПОС терминал, Harpu Pay - Merchant аппликейшн, Цахим хэтэвч аппликейшн болон TDB POS аппликейшн, QR кодын хэвийн ажиллах нөхцөлийг хуанлийн 10 хоног хүртэл хугацаагаар бүрдүүлээгүй, ПОС терминалд эвдрэл, гэмтэл гарсан боловч Банканд мэдэгдэж холбогдох арга хэмжээ аваагүй болон бусад шалтгаанаар Хэрэглэгч болон Банкны нэр хүндэд муугаар нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулсан бол Банкнаас сануулах арга хэмжээ авах, хэрэв энэхүү байдал цаашид дахин давтагдсан тохиолдолд Гэрээг цуцалж, учирсан хохирол, зардал, төлбөл зохих төлбөрийг бүрэн төлүүлэх;
- 5.2.15. Мерчантад Гэрээ байгуулсантай холбогдуулан шилжүүлсэн картын тоног, төхөөрөмжийн өмчлөх эрхийг хадгалах;
- 5.2.16. Банк шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхий нөхцөл болон Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд энэхүү өөрчлөлтөө гэрээ болон зохих журмын дагуу Мерчантад мэдэгдэх;
- 5.2.17. Банк нь Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу аливаа татвар хураамжийг мерчантын данснаас суутгах;
- 5.2.18. Банк нь “Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем”-ийн хүрээнд Татварын ерөнхий газарт Мерчант дээр хийгдсэн гүйлгээний мэдээллийг илгээх;
- 5.2.19. Ерөнхий нөхцөлд бие даан нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 5.2.20. Сүлжээ, системийн доголдлоос үүссэн амжилтгүй гүйлгээ нь мерчантын түр дансанд давхар болон илүү дүнгээр орсон тохиолдолд гүйлгээг ҮЦТ-ийн тайлан, холбогдох программд шалган баталгаажуулсны үндсэн дээр үл маргах журмаар мерчантын түр данснаас буцаалтын гүйлгээ хийх;
- 5.2.21. Банк нь Бямба, Ням гараг, нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд хийгдсэн гүйлгээний хаалтанд тус гэрээний 6.1.4 дэх заалтад заасан заалтын дагуух гүйлгээг “сэжигтэй”, “луйвар”-ын шинжтэй гэж үзсэн тохиолдолд, хэвийн эсэхийг шалган баталгаажуулсны дараа ажлын 1 хоногийн дотор гүйлгээг шилжүүлэх;
- 5.2.22. Хууль болон Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Мерчантаас шаардах.

ЗУРГАА. МЕРЧАНТЫН ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Мерчант дараах үүрэгтэй:

- 6.1.1. Мерчант нь Хэрэглэгчийг түүнээс худалдан авсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төлбөрийг Гэрээнд заасны дагуу төлбөр хүлээн авах аль сувгаар хийхийг Хэрэглэгчээс лавлан, гүйлгээ амжилттай гүйцэтгэсэн даруйд амжилттай гүйлгээний баримтыг үндэслэн уг төлбөрийг бүрэн төлсөнд тооцож холбогдох үйлчилгээгээ үзүүлэх;
- 6.1.2. Картаар, Qpay QR үйлчилгээ, TDB QR үйлчилгээ, Ви чат пэй үйлчилгээгээр үйлчилсэнтэй холбогдуулан бараа, үйлчилгээний үнийн дүн дээр нэмж аливаа шимтгэл суутгал тооцохгүй байх;
- 6.1.3. Карт, QR код, Ви чат пэй төлбөр тооцоог Хэрэглэгчийн нүдэнд ил тод байдлаар хийх;
- 6.1.4. Картаар, Qpay QR үйлчилгээ, TDB QR үйлчилгээ, Ви чат пэй үйлчилгээгээр хийсэн сэжигтэй болон луйврын шинжтэй байж болзошгүй гүйлгээ бүрийг Банканд нэн даруй 1800-1977; 1900-1977 дугаарт холбогдох болон info@tdbm.mn цахим шуудангаар мэдэгдэж байх;
- 6.1.5. ПОС терминалд нэмэлт төхөөрөмж, хуурамч карт уншигч суурилуулсан эсэхэд тогтмол хяналт тавих;
- 6.1.6. Apple Pay и-мерчант нь системийн тохиргоо, холболт, маркетингийн үйл ажиллагааг тохируулахдаа Банкнаас хүргүүлсэн бичиг баримт болон Apple-ийн холбогдох стандартыг дагаж мөрдөнө;
- 6.1.7. Картын болон Qpay QR үйлчилгээ, TDB QR үйлчилгээ, Ви чат пэй үйлчилгээг төлбөрт хүлээн авч үйлчлэхдээ дараах шаардлагыг хангаж ажиллана:
- 6.1.7.а. Гээгдсэн, хулгайд алдагдсан, бусад дамжуулсан, бусад хууль бус байх сэжигтэй картыг болон гар утсаар хийгдэж буй гүйлгээг төлбөрт хүлээн авахгүй байх;
- 6.1.7.б. Зөвхөн Банкнаас зөвшөөрлийн код олгогдсон карт, гүйлгээний дүнгээр төлбөр тооцоог гүйцэтгэх;
- 6.1.7.в. Картыг төлбөрт хүлээж авахдаа ПОС терминал болон Harpu Pay - Merchant аппликейшн дээр хэрэглэгчээр пин кодыг оруулан гүйлгээ хийх (Хэрэглэгчээс картын пин кодыг асууж, хэрэглэгчийн өмнөөс төхөөрөмжид оруулахгүй.);
- 6.1.7.г. Хэрэглэгч бараа үйлчилгээгээ буцаах, картнаас давхардуулан төлбөр гарган авсан тохиолдолд зохих журмын дагуу зөвхөн буцаах гүйлгээ хийх бөгөөд нэгтгэлийн гүйлгээ, хаалтын гүйлгээ хийсний дараа гүйлгээ буцаах болсон тохиолдолд нэн даруй Банкны 1800-1977; 1900-1977 дугаарт холбогдох болон info@tdbm.mn цахим шуудангаар мэдэгдэж, залруулгын гүйлгээ хийлгэх ба бэлэн мөнгийг Хэрэглэгчид олгохгүй байх, хэрэв олгосон тохиолдолд холбогдон үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
- 6.1.7.д. Банкнаас шаардсан эсхүл сэжигтэй луйврын шинжтэй үйлдэл гаргасан байж болзошгүй Хэрэглэгчийн баримт бичгийг шалгаж уг Хэрэглэгч мөн эсэхийг баталгаажуулах;
- 6.1.7.е. Луйврын гүйлгээ хийхээр оролдсон тохиолдолд нэн даруй Банкны 1800-1977; 1900-1977 дугаарт холбогдох болон info@tdbm.mn цахим шуудангаар яаралтай холбоо барьж, Банкны холбогдох ажилтнаас өгсөн удирдамж, зааврын дагуу холбогдох арга хэмжээг авах болон картыг хураан авч, Банкны холбогдох ажилтанд яаралтай хүлээлгэн өгөх;
- 6.1.7.ж. ПОС терминалд картын дугаарыг гараар оруулахгүй байх;
- 6.1.8. Худалдаа, хөгжлийн банкны карт болон Худалдаа, хөгжлийн банкны Гэрээт банкуудын картыг Банкны ПОС терминал дээр заавал уншуулах, бусад банкуудын картуудыг Банкны ПОС терминал дээр хамгийн багадаа 50 хувийг уншуулах;
- 6.1.9. TDB POS аппликейшн болон QR мерчант аппликейшнд шинээр бүртгэл үүсгэхэд Банкнаас шинээр илгээсэн болон үйлчилгээ авах явцдаа Банканд хүсэлт гарган шинэчлүүлсэн нэвтрэх нууц үгээ үйлчилгээнд эхний нэвтрэлтээр заавал сольж ашиглах;

6.1.10. Банк Мерчантын нэвтрэх нэр, нууц үгсийн талаарх мэдээллийг Мерчантаас авахаар шаардахгүй тул Банктай ижил төстэй нэр, цахим хаягаас хандаж байгаа аливаа хүсэлтэд мэдээллээ өгөхгүй байх үүрэгтэй ба үүнээс үүдэн гарсан хохирлыг бүрэн хариуцах. Ийм хүсэлт ирсэн тохиолдолд Банканд нэн даруй 1800-1977, 1900-1977 дугаарт холбогдох (гадаадаас 976-70161988) болон info@tdbm.mn цахим шуудангаар мэдэгдэх;

6.1.11. TDB POS аппликейшн болон QR мерчант аппликейшнд нэвтрэх нууц үгээ хамгийн багадаа зургаан сар тутам сольж хэвших;

6.1.12. Happy Pay - Merchant аппликейшн, TDB POS аппликейшн болон QR мерчант аппликейшнийг ашиглаж дууссан даруйдаа программаас бүрэн гарч байх, энэ үүргийг биелүүлээгүйгээс үүдэн гарах хохирлыг бүрэн хариуцах;

6.1.13. Ухаалаг төхөөрөмж, ПОС терминал, цахим шуудан хаяг, нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг болон бусад баталгаажуулалтын хэлбэрийг алдсан, бусдад задруулсан гэж үзэж байгаа болон ПОС терминал, ухаалаг төхөөрөмжийг гээсэн, нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан аливаа эх үүсвэрээс хандах оролдлого хийсэн, хандсан, гүйлгээ хийх оролдлого гаргасныг мэдсэн тохиолдолд Банканд нэн даруй 1800-1977, 1900-1977 дугаарт холбогдох (гадаадаас 976-70161988) болон info@tdbm.mn цахим шуудангаар мэдэгдэж үйлчилгээний эрхээ түр хаалгах, мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;

6.1.14. Мерчантын ажилтны буруугаас ПОС терминалын аль нэг эд анги гэмтэж, цаашид ашиглагдах боломжгүй болсон тохиолдолд эвдрэлээс хамаарч уг гэмтлийг арилгаж засахтай холбогдон гарсан нийт зардал (сольсон эд ангийн үнэ, тээврийн зардал, Гаалийн татвар, НӨАТ, холбогдох бусад татвар)-ыг Мерчантын түр данс болон банканд дахь бусад харилцах данснаас суутгаж авахыг зөвшөөрөх;

6.1.15. Банкнаас өгсөн картын болон Qpay QR үйлчилгээ, TDB QR үйлчилгээ, Ви чат пэй үйлчилгээний таних тэмдэг бүхий сурталчилгааны материалуудыг үйлчлүүлэгчдийн нүдэнд ил харагдахуйц газарт байрлуулах, зориулалтын дагуу ашиглах, и-мерчант нь өөрийн цахим хуудсандаа байрлуулах өөрийн борлуулалтын сүлжээгээр сурталчлах;

6.1.16. Банкны ажлын амжилт, бизнесийн нэр хүндэд нөлөөлж болохуйц нууц мэдээлэл, техникийн болон программын бүтэц, зохион байгуулалтыг гуравдагч этгээдэд тараах, түгээх, дамжуулах, нийтлэх, задруулах зэргийг хориглох, банк, Хэрэглэгчийн эсрэг ашиглахгүй байх;

6.1.17. Paywave болон Пин кодоор баталгаажсан зөвхөн ПОС терминалын гүйлгээний баримтыг үндэслэн бараа үйлчилгээг олгох бөгөөд уг баримтыг 12 сарын хугацаанд баримтын чанар нь алдагдахгүй байхаар тохиромжтой нөхцөлд хадгалах, шаардлагатай тохиолдолд Мерчант нь и-мерчант, Happy Pay - Merchant аппликейшн болон TDB POS аппликейшний гүйлгээний баримтын цахим хувь, үйл ажиллагаа явуулж буй газрын хяналтын камерын бичлэг, бусад энэ гэрээнээс үүссэн асуудлыг шийдвэрлэхэд хамааралтай нотлох баримт, мэдээллийг Процессор байгууллага болон Банканд ажлын 10 хоногт гаргаж өгөх;

6.1.18. Банкнаас шаардсан тохиолдолд гүйлгээний баримт, тооцооны хуудсыг ажлын 3 хоногийн дотор авч ирж өгөх, заасан хугацаанд холбогдох баримтыг авч ирж өгөөгүй, гүйлгээний баримт шаардлага хангахгүй (гарын үсэгтгүй, харагдахгүй, балласан гэх мэт) тохиолдолд Банканд учирсан аливаа хохирол болон бусад бүх зардлыг хариуцах;

6.1.19. Гүйлгээний мэдээллийн нууцлалыг хадгалах, хууль бус зорилгоор ашиглахаас сэргийлэх, Хэрэглэгчийн нэр, картын дугаар, гүйлгээний хэмжээ болон санхүүгийн бусад мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;

6.1.20. Хэрэглэгчээс гаргасан гомдол, маргааныг хурдан, шуурхай шийдвэрлэж, заасан хугацаанд хариу өгч байх;

6.1.21. Мерчант нь Гэрээний хугацаанд данснаасаа Банкнаас тогтоосон шимтгэл, хураамжийг Ерөнхий нөхцөлд заасны дагуу төлөх, суутгахыг зөвшөөрсөн ба шимтгэл, хураамжаа төлөх;

6.1.22. Банкнаас олгосон ПОС терминал, Happy Pay - Merchant аппликейшн, TDB POS аппликейшний нэвтрэх эрхийг бусдад дамжуулахгүй, ашиглуулахгүй, ашиглах нөхцөл олгохгүй байх, түүнийг ашиглаж, гадаад улсаас хөрөнгө оруулалт татах болон аливаа хууль бус гүйлгээ гарахаас сэргийлэх;

6.1.23. Мерчант нь зөвхөн өөрийн бараа, үйлчилгээг худалдсаны төлбөрийг ПОС терминал, Happy Pay - Merchant аппликейшн, TDB POS аппликейшн, Цахим хэтэвч аппликейшн, QR мерчант аппликейшн ашиглан гүйцэтгэх ба и-мерчант нь өөрийн сайт дахь интернэт дэлгүүрээр худалдаалж буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар болон зар сурталчилгааныхаа үнэн зөвийн төлөө хариуцлага хүлээх;

6.1.24. Мерчант нь “Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем”-ийн хүрээнд ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний мэдээллийг Татварын ерөнхий газарт илгээхийг Банканд зөвшөөрөх;

6.1.25. Банкнаас олгосон терминалыг Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах буюу зөвхөн гэрээнд заасан байршилд буюу урьдчилан тодорхойлсон нутаг дэвсгэрийн хүрээнд ашиглах;

6.1.26. Мерчантын хаяг, холбоо барих утас, цахим шуудан болон орлого хүлээн авах данс өөрчлөгдсөн тухай бүр банкны салбар нэгжид хандан, мэдээллийн шинэчлэлт хийлгэх;

6.1.27. Гүйлгээ тулгалтыг хийхэд орлогын гүйлгээ нь дутуу, эсхүл илүү орсон тохиолдолд Банканд хуанлийн 10 хоногийн дотор мэдэгдэх;

6.1.28. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх ба хуулиар хүлээсэн үүргийг зөрчих аливаа үйлдлийг гаргахгүй байх;

6.1.29. ПОС терминал, Happy Pay - Merchant аппликейшн, TDB POS аппликейшн, QR мерчант аппликейшн, Цахим хэтэвч аппликейшн, и-мерчант болон Apple Pay и-мерчантын вэб сайтаар дамжин хийгдэж буй гүйлгээний мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хадгалах, хууль бус зорилгоор ашиглахаас сэргийлэх, Хэрэглэгчийн нэр, гүйлгээний мэдээлэл, гүйлгээний дүн болон санхүүгийн бусад мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй, алдахгүй байх;

6.1.30. Хууль болон Гэрээнд заасан үүргээ биелүүлэх.

6.2. Мерчант дараах эрхтэй:

6.2.1. Төлбөр хүлээн авах сувгаар хийгдсэн гүйлгээний төлбөрийг Гэрээнд заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг Банкнаас шаардах;

6.2.2. ПОС терминал, Happy Pay - Merchant аппликейшн, TDB POS аппликейшн, QR мерчант аппликейшн, Цахим хэтэвч аппликейшн, и-мерчант үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад Банкнаас шалтгаалах зүйлсийг шаардах;

6.2.3. Гүйлгээний маягт, цаас болон сурталчилгааны материал дууссан тохиолдолд Банкнаас шаардаж авах;

6.2.4. Банкнаас карт, Qpay QR үйлчилгээ, TDB QR үйлчилгээ, Ви чат пэй үйлчилгээний төлбөр тооцоотой холбоотой тайлан мэдээ гаргуулж авах;

6.2.5. Банкнаас явуулж буй Мерчантыг сурталчлах ажиллагаанд хамрагдах;

6.2.6. Банкны интернэт төлбөр хүлээн авах үйлчилгээнд ашиглаж байгаа программ хангамжид өөрчлөлт оруулсан бол түүний дагуу өөрийн цахим сайтын холболтыг шинэчлэхийг шаардах, хамтран ажиллах;

6.2.7. Банк Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс Мерчантад удаа дараа хүндрэл учруулсан бол түүнийг залруулах, дахин үүсэхгүй байхыг шаардах бөгөөд энэхүү шаардлагыг биелүүлээгүй бол Гэрээг цуцлахыг шаардах;

6.2.8. Хууль болон Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

7.1. Гэрээ нь байгуулагдсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд дуусах хугацаагүйгээр хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2. Талуудын аль нэг нь гэрээг цуцлах саналаа бичгээр гаргасан тохиолдолд нөгөө тал хүлээн авч, хариу мэдэгдсэн, эсхүл хариу мэдэгдээгүй бол хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногийн дараа гэрээ цуцлагдаж, дуусгавар болсон гэж үзнэ.

НАЙМ. МЕРЧАНТЫН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

8.1. Мерчантын хувийн мэдээлэл гэдэг нь Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар тодорхойлсон (Биометрик мэдээлэл, генетик мэдээлэл, хөрөнгийн мэдээлэл, хүний хувийн мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл, цахим тодорхойлогч, эрүүл мэндийн мэдээлэл гэх мэт) бүхий л мэдээллийг ойлгоно.

8.2. Банк нь хууль тогтоомжид заасны дагуу Харилцагчийг таних, баталгаажуулах, бүртгэх, Харилцагчийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх, Гэрээнд заасны дагуу мэдээлэл хүргэх, Мерчантад холбогдох асуудлаар хууль хяналтын байгууллага болон төрийн эрх бүхий байгууллагад хандах (хүсэлт, гомдол, мэдээлэл, өргөдөл, нэхэмжлэл, хариу тайлбар гаргах зэрэг), мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааг үзүүлэхтэй холбоотой зэрэг зорилгоор Харилцагчийн хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана.

8.3. Мерчант Гэрээг байгуулснаар Банк нь Мерчантын мэдээллийг үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээнд сайжруулалт хийх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох зорилгоор ашиглах, уг зорилгын хүрээнд хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд Гэрээний үндсэн дээр дамжуулахыг зөвшөөрч байгаа болно.

8.4. Банк нь Мерчантын хувийн мэдээллийг хугацаагүйгээр ашиглах, боловсруулах эрхтэй байна.

8.5. Банк нь Мерчантын хувийн мэдээллийг олон нийтэд ил болгохгүй бөгөөд цуглуулах, ашиглах, боловсруулах явцад санаатай болон санамсаргүйгээр алдах, устгах, өөрчлөх, хуулбарлах, бусад хууль бус ажиллагаанаас хамгаална.

8.6. Банк нь Мерчантыг танин, баталгаажуулсны үндсэн дээр бүртгэл хийх шаардлагын дагуу Мерчантын баримт бичиг, Төрийн мэдээлэл солилцооны системд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх тул Харилцагч нь Гэрээнд гарын үсэг зурснаар тус системд бүртгэгдсэн өөрийн хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахыг зөвшөөрч байгаагаа баталгаажуулж байгаа болно.

8.7. Мерчант нь Банканд хувийн мэдээллээ үнэн зөв өгөх үүрэгтэй бөгөөд өөрийн хувийн мэдээлэлд өөрчлөлт орвол нэн даруй Банканд мэдэгдэнэ.

8.8. Банк нь Гэрээ болон хуульд зааснаас бусад тохиолдолд Мерчантын мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй.

ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ, ҮҮСЭХ ҮР ДАГАВАР

9.1. Гэрээ нь дараах үндэслэлээр цуцлагдаж, дуусгавар болно:

9.1.1. Талуудын аль нэг нь ноцтой зөрчил гаргасан бол нөгөө тал Гэрээний 9.2 дахь хэсэгт заасан хугацааг үл харгалзан Гэрээг нэг талын санаачилгаар;

9.1.2. Аль нэг тал Гэрээг дуусгавар болгох хүсэлтээ бичгээр гаргаж, нөгөө тал хүлээн зөвшөөрсөн;

9.1.3. Талуудын аль нэг нь татан буугдсан, эсхүл дампуурсныг шүүхээс зарласан;

9.1.4. Гэрээний 13.2 дахь хэсгийг үндэслэн байгуулсан нэмэлт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл ноцтой зөрчсөн бол;

9.1.5. Монгол Улсын хууль тогтоомж, Гэрээнд заасан бусад үндэслэл.

9.2. Гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Гэрээг цуцлах талаар талуудын аль нэг нь бичгээр санал тавьснаас хойш хуанлийн 30 хоногт Гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд энэ хугацаанд Гэрээг цуцлах асуудлыг талууд харицан тохиролцож, эцэслэн шийдвэрлэнэ.

9.3. Талууд хүндэтгэн үзэх шалтгаанаар Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа 30 хоногоос доошгүй хугацааны өмнө бичгээр мэдэгдэж, Гэрээг өөрчлөх буюу цуцлахыг шаардах эрхтэй.

9.4. Дараах тохиолдлуудыг ноцтой зөрчилд тооцно:

9.4.1. Мерчант Гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчин, Хэрэглэгч болон Банканд аливаа хохирол, зардал учруулсан бол Банк нэг талын санаачилгаар;

9.4.2. Банк Гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн бөгөөд түүнийг засах шаардлагыг биелүүлээгүй бол Мерчант нэг талын санаачилгаар;

9.4.3. Луйврын гүйлгээний нийт гүйлгээнд эзлэх хувь Банкны зохих түвшинээс хэтэрсэн гэж Банк үзвэл Банк нэг талын санаачилгаар;

9.4.4. Гэрээнд заасан ПОС терминалыг буцаан авах үндэслэл бүрдсэн бөгөөд мерчант нь санаатайгаар төхөөрөмжийг хүлээлгэн өгөхгүй байх;

9.4.5. Гэрээний 2.1.3 дахь заалтад заасны дагуу сар бүр гурван сая төгрөгөөс бага гүйлгээ (гурван сарын хугацаанд) ПОС терминалаар гарсан;

9.4.6. Терминал дээр 3 сарын хугацаанд гүйлгээ огт гараагүй;

9.4.7. Мерчант нь луйврын гүйлгээ хийхэд оролцсон гэж банк үзсэн бол;

9.4.8. Банк мерчантыг Гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн гэж үзсэн.

9.5. Гэрээний 9.4 дэх хэсэгт заасан үндэслэлээр Гэрээг цуцлах тохиолдолд Мерчантад аливаа хэлбэрээр урьдчилан мэдэгдэх шаардлагагүй бөгөөд Гэрээний нөхцөл хангаагүй буюу зөрчигдсөн өдрөөс эхлэн Банк нь тухайн мерчантын холболтыг салгах, гэрээг шууд цуцлах, ПОС терминалыг буцаан авна.

9.6. Гэрээ цуцлагдаж дуусгавар болгосон тохиолдолд Банк Мерчантад үйлчилгээ үзүүлэх хугацаан дахь бүх суурилуулахтай холбоотой маркетингийн материалууд, ПОС терминал бусад гүйлгээний баримтуудыг буцаан авах бөгөөд эвдрэл учруулсан буюу алдаж үрэгдүүлсэн байвал үүнээс ирээдүйд үүсэх хохирол, зардлыг Мерчант нь Банканд бүрэн төлнө.

9.7. Банкны ажилтан хүлээлцэх акт бичин ПОС терминалыг хураан авсан тохиолдолд Гэрээ дуусгавар болно.

АРАВ. ХАРИУЦЛАГА

10.1. Талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан бодит хохирол, зардлыг Гэрээг зөрчсөн тал бүрэн хариуцна.

10.2. Гэрээ нь цуцлагдсан, дуусгавар болсон тохиолдолд Гэрээг хүчин төгөлдөр байх үед үүссэн төлбөр тооцооны эрх үүрэг нь бүрэн биелэгдэж дуусах хүртэл хугацаанд энэхүү Гэрээний зохицуулалт талуудын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд түүнээс үүссэн хохирол, зардлыг шаардах эрх ч мөн адил хэвээр хадгалагдана.

10.3. Мерчант нь Банкнаас олгосон ПОС терминал төхөөрөмж, терминалын мэдээллийг бусад дамжуулахгүй, ашиглуулахгүй, ашиглах нөхцөл олгохгүй байх, түүнийг ашиглаж аливаа хууль бус гүйлгээ гарахаас сэргийлэх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ зөрчсөнөөс үүдэн гарах хохирлыг хариуцна.

10.4. Мерчант нь Гэрээний 6.1.6.в - д заасан баталгаажуулалтыг хийгээгүйтэй холбоотой гарах эрсдэлийг өөрөө хариуцна.

10.5. ПОС терминал, Нарру Pay мерчант терминал, и-мерчант Apple Pay и-мерчантын вэб сайт, Qpay QR үйлчилгээ, TDB QR үйлчилгээ, Ви чат пэй үйлчилгээ, Цахим хэтэвч үйлчилгээ болон Manual entry гүйлгээ хийхэд шаардлагатай картын нууцлал бүхий мэдээллүүд, Хэрэглэгчийн найдвартай байдал, гүйлгээний үнэн зөвийг мерчант батлан хариуцах үүрэгтэй бөгөөд Хэрэглэгчийн

мэдээллийг байгууллага дотроо, эсхүл гуравдагч этгээдэд задруулсан, мэдээллийг алдсантай холбогдон гарсан аливаа картан маргаантай болон луйврын гүйлгээний асуудал, эрсдэлийг мерчант бүрэн хариуцах;

10.6. Мерчант үүссэн аливаа картан маргаантай болон луйврын гүйлгээний асуудал, эрсдэл үүссэн үед байгууллагын картан гүйлгээний түр болон харилцах данснаас үл маргах журмаар суутган авахыг үүгээр зөвшөөрч байна.

АРВАН НЭГ. НУУЦЛАЛ

11.1. Мерчант нь Гэрээ байгуулсантай холбогдуулан олж, мэдэж авсан Банк болон Хэрэглэгчийн талаарх аливаа мэдээлэл, баримтыг Гэрээний хугацаанд болон түүнээс хойш хэдийд ч өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахгүй, Банкны болон түүний Харилцагчийн эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

11.2. Мерчант нь Qpay QR үйлчилгээ, TDB QR үйлчилгээ, Ви чат пэй үйлчилгээтэй холбоотой гүйлгээ, төлбөр тооцооны мэдээллийг зөвхөн энэхүү гэрээнд заасан зорилгын дагуу ашиглана.

11.3. Мерчант нь энэхүү гэрээний 11.1, 11.2-д заасан нөхцөлийг зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

АРВАН ХОЁР. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

12.1. Картын paywave, эсхүл пин кодоор баталгаажсан гүйлгээний баримт нь аливаа маргаантай гүйлгээг шийдвэрлэх үндсэн нотлох баримт болно. Гүйлгээний баримт дээрх мэдээлэл арилсан, балласан зэрэг шалтгаанаар шаардлага хангаагүй ПОС терминалын гүйлгээний баримтыг Мерчант өөрөө хариуцаж, маргаантай гүйлгээг Банкны оролцоогүйгээр бие даан шийдвэрлэх, хариуцах үндэслэл болно.

12.2. Мерчант нь маргаан үүсгэх буюу Хэрэглэгчээс бараа, үйлчилгээний төлбөрийг дутуу авсан, эсхүл огт авч чадаагүй тохиолдолд бараа үйлчилгээг авсныг нотлох үүднээс баримт болон бичгээр хүсэлт гарган маргаан үүсгүүлж болох бөгөөд холбогдох шимтгэлийг төлнө.

12.3. Хэрэглэгчийн зүгээс бараа үйлчилгээний төлбөрийг илүү дүнгээр, эсхүл давхар авсан талаар мэдэгдэж, маргаан үүсгэсэн тохиолдолд Мерчантаас ирүүлсэн “Гүйлгээ баталгаажуулах маягт”, албан бичиг, эсхүл Банканд бүртгэлтэй цахим шуудан, мессеж (133133 дугаарт)-ээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн, холбогдох данснаас буцааж, шилжүүлснээр маргаан шийдвэрлэгдэнэ.

12.4. Мерчант дээр хийгдсэн бусад аливаа маргаантай болон луйврын гүйлгээг Visa Inc, MasterCard Worldwide, JCB International, UnionPay International, Diners Club International, Discover Financial Service зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын шийдвэрлэх дүрэм, журам, заавар, Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв болон Банкны холбогдох журам, заавар энэхүү Гэрээнд заасан журмын дагуу шийдвэрлэнэ. Гомдлыг шийдвэрлэх Ерөнхий хугацаа хуанлийн 180 хоног байх бөгөөд тухайн маргааны төрлөөс шалтгаалан холбогдох дүрэм, журам, зааварт заасны дагуу тодорхойлогдоно.

12.5. ПОС терминал, Нарру Pay мерчант терминал, И-коммерс терминал, Apple Pay и-коммерс терминал, Qpay QR терминал, TDB QR терминал, Цахим хэтэвчний In-app, Deelink үйлчилгээ болон Ви чат пэй гүйлгээтэй холбоотой бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг буцаасан, илүү болон давхар төлөгдсөн, буруу шилжүүлсэн, бараа үйлчилгээний төлбөр төлөгдөөгүй, эсхүл дутуу төлөгдсөн зэрэг маргааныг хүлээн авч Мерчант, Банк, Процессор байгууллага гэсэн гурван талын оролцоотойгоор шийдвэрлэнэ.

12.6. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.

12.7. Хэрэв Гэрээний 12.1 - 12.6 - д заасан журмаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАН ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

13.1. Гэрээний дагуу ямар төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авч байгаа болох нь Харилцагчийн уг гэрээг байгуулах үед гаргасан болон цаашид гаргах мерчантын үйлчилгээний хүсэлтээр тодорхойлогдоно.

13.2. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, Гэрээг цуцалснаар буюу Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.

13.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож, нэмэлт Гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

13.4. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, Гэрээтэй холбогдон нэг талаас нөгөө талдаа гаргаж буй аливаа санал, мэдэгдэл, хүсэлтийг бичгээр, хуанлийн 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа Гэрээнд заасан хаягаар баталгаат шуудангаар, эсхүл биечлэн хүргүүлснийг хүчинтэйд тооцно.

13.5. Гэрээний хавсралтууд нь Гэрээний салшгүй хэсэг болно.

13.6. Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

13.7. Гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байгаа Ерөнхий нөхцөл болон түүнд цаашид орох нэмэлт, өөрчлөлтүүд, Гэрээнээс үүссэн маргааныг шийдвэрлэх олон улсын санхүүгийн байгууллага, Монголбанк, Банкны холбогдох дүрэм, журам, заавар нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болно.

13.8. Банкнаас олгосон терминалын эзэмшигч болон түүнийг ашиглах байршил өөрчлөгдөх тохиолдолд Банканд нэн даруй мэдэгдэж, талууд гэрээг шинэчлэн байгуулна.

13.9. Гэрээгээр тусгайлан тайлбарлалгүй ашигласан нэр томъёо болон Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлбарлаж, зохицуулна.

13.10. Гэрээг Талууд өөрсдийн хүсэл зоригийг тэгш эрхийн үүднээс харилцан чөлөөтэй илэрхийлэн, утга агуулга, хууль зүйн үр дагаврыг бүрэн ойлгож байгуулсан болно.

Гэрээг англи, монгол хэлээр бэлтгэсэн. Орчуулгад зөрчил гарсан тохиолдолд монгол хувилбарыг дагаж мөрдөх бөгөөд талууд заавал биелүүлэх үүрэгтэй.

Гэрээ байгуулсан:

Банкийг төлөөлж:

Банкны нэгжийн захирал

..... (.....)

Утас:

Тамга

Мерчантыг төлөөлж:

Захирал

..... (.....)

Утас:

Тамга